



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам” 382 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн дүрэм, бүтэц батлах тухай” А/146 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Хөдөлмөрийн дотоод журмыг нэгдүгээр, хөдөлмөрийн гэрээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхийг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, Төлөвлөт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, албадын дарга, тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан /Ө.Сүрнээ/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Амаржих газрын даргын 2019 оны А/13 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ



Ц.БАТБОЛД